



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

**Биет бус хөрөнгө данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын хөрөнгөд бүртгэлтэй, 994,189,440.00 (есөн зуун ерэн дөрвөн сая нэг зуун наян есөн мянга дөрвөн зуун дөчин) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/15 дугаар захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/466 дугаар тушаалаар тус тус цуцлагдсан газар эзэмших эрх)-ийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, Эрхэлсэн комиссар 3.Баасаннямд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Биет бус хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ДАНСНААС ХАСАХ БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Биет бус хөрөнгийн нэр, хаяг	Ашиглаж эхэлсэн он	Дуусах хугацаа оноор	Тоо, хэмжээ	Хэмжээ /м2/	Нийт үнэ /төгрөг/
1	УБ, БЗД-ийн 11-р хороо Богдхан уулын ДЦГ-ын Төр хурхын аманд байрлалтай аялал жуулчлалын зориулалттай газар	2014	2019	1	10000	960,048,000.00
2	Баянгол дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 523 м.кв орон сууцны зориулалттай газар	2021	2036	1	523	34,141,440.00
	ДҮН					994,189,440.00
НИЙТ ДҮН						
(есөн зуун ерэн дөрвөн сая нэг зуун наян есөн мянга дөрвөн зуун дөчин төгрөг)						